

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
(ЖИЛИЙН ЭЦСЭЭР)**

2025 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

№	Стратегийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн явц, биелэлт
1	2	3	4	5	6	7	8
1. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, ИДЭВХЖҮҮЛЭХ							
1.1	Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээний үнэлгээнд үндэслэн богино, дунд хугацааны сургалтад хамруулах, тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлнэ.	Төрийн албан хаагчийг Удирдлагын академийн мэргэшүүлэх зохих багц сургалтад хамруулах	Албан хаагчийн тоо	6	5	7	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 03/2220 дугаар албан бичгийн дагуу нийт албан хаагчдаас Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх богино хугацааны (40 цагийн) сургалтад хамруулах санал авсан. Гэвч хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан уг сургалтын зардлыг албан хаагч өөрийн хөрөнгөөр хариуцах нөхцөлтэй болсон тул хамрагдаагүй. 2025 оны 9 дүгээр сард Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад нийт 7 албан хаагчийг хамруулахаар санал хүргүүлснээс 4 албан хаагч зохих шалгуур хангаж мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж байна.
1.2		Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, мэргэжлийн байгууллага болон бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион	Гүйцэтгэл, хувь	108 удаагийн сургалт 100%	100%	110 удаагийн сургалт 100%	Албан хаагчдын мэдлэг, ур чадвар болон мэргэжлийн чадавхыг тасралтгүй дээшлүүлэх, төрийн үйлчилгээг чанар, үр ашигтай хүргэх зорилгоор Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төв, мэргэжлийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулсан 110 удаагийн сургалт (Танхим 98, Цахим 12)-д давхардсан тоогоор нийт 1505 албан хаагчдыг

1	2	3	4	5	6	7	8
		байгуулсан сургалтад хамруулах					хамруулав. Сургалтуудын агуулга нь төрийн албаны ёс зүй, үйлчилгээний соёл, манлайлал, стратегийн төлөвлөлт, хуулийн хэрэгжилт, мэдээллийн технологийн хэрэглээ, төсөв, санхүүгийн мэдлэг зэрэг чиглэлүүдийг хамарч, албан хаагчдын ажлын гүйцэтгэлд бодит хувь нэмэр оруулсан.
1.3	Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээний үнэлгээнд үндэслэн богино, дунд хугацааны сургалтад хамруулах, тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлнэ.	Байгууллагын алсын хараа, эрхэм зорилгод чиглэсэн, дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор богино, дунд, урт хугацааны сургалтад тогтвор суурьшилтай ажиллаж буй албан хаагчийг гадаад оронд сургалтад хамруулах	Сургалт, семинарын тоо	7 сургалт, семинар	3-5 удаагийн сургалт, семинар	13 удаагийн сургалтын хөтөлбөр	Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээний үнэлгээнд үндэслэн төлөвлөгөөт хугацаанд нийт 13 удаагийн сургалт, семинарт 17 албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хамруулав. Үүнд: 1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Бусан хот хотод зохион байгуулагдсан “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа ба эрт зарлан мэдээлэх систем” сэдэвт сургалт, 2. Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулагдсан “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа ба эрт зарлан мэдээлэх систем” сэдэвт сургалт, 3. Япон Улсын Токио хотод зохион байгуулагдсан “Шинэ хот байгуулахтай холбоотой эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт, институтын ойлголт” сэдэвт сургалт, 4. АНУ-ын Прово мужид зохион байгуулагдсан “Төр, нийтийн удирдлагын тухай” сэдэвт сургалт, 5. Энэтхэг Улсад зохион байгуулагдсан “Course in Progress to Proficiency in English Literation-I” сэдэвт сургалт, 6. Тайван улс Тайпэй хотод зохион байгуулагдсан “Газарзүйн мэдээллийн систем ба газрын менежмент” сэдэвт сургалт,

1	2	3	4	5	6	7	8
							7. Тайван улс Тайпэй хотод зохион байгуулагдсан "Ухаалаг хотын дээд хэмжээний экспо-2025" чуулган, 8. Хятад улс, Гуанжу хотод зохион байгуулагдсан " Тогтвортой хотуудын дэлхийн платформ" сэдэвт сургалт, 9. Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага "КОЙКА"-ийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй МУ-ын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх төслийн хүрээнд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалт, 10. Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан ОУ-ын хамтын ажиллагааны байгууллага "КОЙКА"-ийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй МУ-ын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх төслийн хүрээнд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалт, 11. Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ухаалаг, дижитал тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах төслийн хүрээнд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалт, 12. Нидерланд улсад зохион байгуулагдсан "Монголын Мянганы сорилтын сангаас МУ-ын усны компакт гэрээний хүрээнд усны операторуудын түншлэлийн сургалт, хөтөлбөр" сэдэвт семинар, 13. Испани, Франц улсад зохион байгуулагдсан "Монголын Мянганы сорилтын сангийн хэрэгжүүлж байгаа Монгол Улсын усны компакт гэрээний хүрээнд Хаягдал ус дахин боловсруулах төслийн хүрээнд олон улсын

1	2	3	4	5	6	7	8
							туршлага судлах сургалт, аялал” сэдэвт семинар,
1.4		Салбарын чиглэлээр доктор, магистрантурын сургалтад албан хаагчдыг суралцах боломжоор хангах	Гүйцэтгэл, хувь	2	2-5 албан хаагч	2 албан хаагч	Отгонтэнгэр их сургуулийн Хууль, эдийн засгийн сургуульд “Эрх зүй” мэргэжлээр магистрын сургалтыг 2024-2025 онд 1 албан хаагч суралцаж магистрын зэрэг хамгаалсан. Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Барилга, архитектурын сургуульд “Хот ба бүс нутгийн төлөвлөлт” мэргэжлээр магистрын зэрэг горилох сургалтад 1 албан хаагч 2024-2025 онд үргэлжлэн суралцаж байна.
1.5		Албан хаагчдыг мэргэшлийн зэрэг горилох болон сунгах сургалтад суралцуулах	Гүйцэтгэл, хувь	8 албан хаагч	8-10 албан хаагч	29 Албан хаагч 100%	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зохион байгуулсан “Барилгын эрчим хүчний үр ашиг” сэдэвт тасралтгүй мэргэжил дээшлүүлэх 3 багц сургалтад 13 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авав. - Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан Нутгийн захиргааны байгууллагуудад олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2015 дотоод аудитор бэлтгэх сургалтад 2 албан хаагч хамрагдаж Дотоод аудиторын гэрчилгээ авав. - Эс Эф Си Эс ХХК-аас зохион байгуулсан чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын аудиторын сургалтад 2 албан хаагч хамрагдаж аудитор/Тэргүүлэх аудиторын гэрчилгээ авав. - “Худалдан авах үйл ажиллагааны хөтөч” НҮТББ-тай гэрээ байгуулан, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын Б блок, 2 давхрын 205 тоот сургалтын танхимд 2025.05.06-2025.05.07-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан бөгөөд нийт 14 албан хаагч хамрагдсанаас 8 албан хаагч АЗ гэрчилгээ тус тус авсан. - Авлигатай тэмцэх газрын, Нийслэлийн гэмт

1	2	3	4	5	6	7	8
							хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах сургагч багш” бэлтгэх анхан шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авав.
1.6		Албан хаагчдыг мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, чадавхыг тасралтгүй хөгжүүлэх чиглэлээр ажлын байран дээр сургалт зохион байгуулах - Албан тушаалын ажлын байрны сургалт - Ажлын бүтээмжийг дээшлүүлэх сургалт - Ёс зүйн хэм хэмжээ Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт;	Сургалтын тоо	8 удаагийн сургалт	5-аас доошгүй удаа	9 удаагийн сургалт	Төлөвлөгөөт хугацаанд 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийт 134 албан хаагчийг хамруулав. Үүнд: 1. Төрийн албаны тухай хууль, Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам, 2. 2025 оноос мөрдөгдөж байгаа хууль тогтоомжууд 3. Албан хэрэг хөтлөлт, анхаарах асуудлууд, 4. Хот байгуулалт, хотын стандартын газрын бүтэц, орон тоо, чиг үүргийн танилцуулга, "Газрын хөдөлмөрийн дотоод журам", дотоод сүлжээ түүний ашиглалт 5. Байгууллагын соёл, хувь хүний хөгжил сэдэвт сургалт 6. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж болох ДРОН-ыг нисгэх, өгөгдөл, мэдээллийг боловсруулах программ хангамжийн танилцуулга, хэрэглээ, дадлагажуулах практик сургалт Авлигатай тэмцэх газар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 3 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 127 албан хаагчийг хамрууллаа. Үүнд: 7. Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалт 8. ХАСХОМ гаргах заавар 9. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён

1	2	3	4	5	6	7	8
							гэгээрүүлэх сургалт
1.7	Ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлнэ.	Албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр сэтгэл ханамжийн судалгаа авч, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Гүйцэтгэл, хувь	1 судалгаа, 70%	1 судалгаа, 100%	1 судалгаа, 100%	Залуучуудын хөгжлийн зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан албан хаагчдын ажиллах орчин нөхцөл, хамт олны харилцаа, сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр албан хаагчдаас судалгаа авч ажиллав. Судалгааг цахим хэлбэрээр Google Form ашиглан нууцлалтайгаар зохион байгуулж, байгууллагын нийт 105 албан хаагчаас 79 албан хаагч (75%) хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 69.6% нь хамт олны уур амьсгалыг нөхөрсөг, сайн гэж үнэлсэн байна. Ажлын орчныг сайжруулах талаар гарсан саналд үндэслэн дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэв. Үүнд: 1. Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах 2. Хурлын өрөө, коридор зэрэг талбайг тохижуулах 3. Хамт олны арга хэмжээг тогтмол зохион байгуулах 4. Илүү цагаар ажиллуулахгүй байх, уян хатан ажлын цагийн горим нэвтрүүлэх.
1.8	Ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлнэ.	Албан хаагчдыг орчин үеийн шаардлага, ажлын байрны онцлогт нийцсэн, ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн цахим мэдээллийн систем, техник хэрэгслээр үе шаттайгаар хангаж, ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх	Гүйцэтгэл, хувь	18 нэр төрлийн тоног төхөөрөмж 719,325,073 төгрөг 100%	Программ хангамжийн хугацааг сунгах, хэвийн ажиллагааг бүрэн хангах	7 нэр төрлийн 176 ширхэг техник, тоног төхөөрөмж, ажлын ширээ, сандал, шүүгээ 360,425,420 төгрөг	Албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор 2025 онд 249,642,800 төгрөгийн үнэ бүхий 50 ширхэг компьютер, 3 ширхэг олон үйлдэлт принтер, 110,782,620 төгрөгийн үнэ бүхий 52 ширхэг ажлын ширээ, шүүгээ, хаалт бүхий иж бүрдэл, 52 ширхэг сандал, 12 ширхэг шилэн хаалгатай бичиг баримтын шүүгээ, 7 ширхэг хувцасны шүүгээ зэрэг нийт 7 нэр төрлийн 176 ширхэг техник, тоног төхөөрөмж, ажлын ширээ, сандал, шүүгээг шинээр олгосон байна.

1	2	3	4	5	6	7	8
1.9	Албан хаагчдыг хөдөлгөөний хомсдол, халдварын бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх боломжийг бүрдүүлнэ.	Албан хаагчдын чөлөөт цагаар төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулж, тэднийг идэвхтэй оролцуулах. (Спорт хамтлагийн жилийн ажлын төлөвлөгөө, баталсан удирдамжийн дагуу)	Арга хэмжээний тоо	2	2	5 удаагийн тэмцээн уралдаан	Газрын албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх боломж, бололцоог бүрдүүлэх, улмаар эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор спортын арга хэмжээ зохион байгуулж ажиллах үүрэг бүхий Спорт хамтлагийг 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр Газрын даргын 2025 оны А/09 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан. Спорт хамтлагаас хариуцан зохион байгуулсан 5 удаагийн тэмцээн уралдаанд нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцсон. - 2025.02.15 Скай резорт цанын бааз - “Өвлийн спортын наадам” арга хэмжээнд 16 албан хаагч, - 2025.05.01-04 “Газрын харилцааны ажилтны өдрийн нэрэмжит Шилжин явах цом”-ын төлөөх 2025 оны улсын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээн байгууллагын шигшээ багийн 25 албан хаагч, - 2025.05.24 “Улаанбаатар марафон – 2025” олон улсын гүйлтийн тэмцээний 5км-т 23 албан хаагч 10км-т 3 албан хаагч, 21км-т 2 албан хаагч нийт 28 албан хаагч. - 2025.10:03-05 Барилгын салбар үүсэж хөгжсөний 99 жилийн ойн хүрээнд Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын нэрэмжит 5 төрөлт спортын наадамд байгууллагын шигшээ багийн 25 албан хаагч, - 2025.10.06-11 Хот байгуулалт, хотын стандартын газрын 9 төрөлт спорт арга хэмжээнд байгууллагын нийт албан хаагчид 5 багт хуваагдаж, байгууллагын аварга баг хамт олныг шалгаруулсан.

1	2	3	4	5	6	7	8
1.10	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Арга хэмжээний тоо	2 удаа	1-2 удаа	2 удаагийн үзлэг	Нийслэлийн Засаг даргын удирдах ажилтны шуурхайгаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу албан хаагчдыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2025 оны 03 дугаар сарын 20, 21-ний өдөр зохион байгуулав. Нийт 66 албан хаагчийг цус, шээсний ерөнхий шинжилгээ, 6 төрлийн үзлэгт оношлогоонд хамруулав, Үүнээс 36 албан хаагч ходоодны дуран хийлгэж, 41 албан хаагч 5 өдрийн гадуур эмчилгээнд хамрагдсан байна. Албан хаагчдыг эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулахаар нэгжүүдээс санал авч Санмедикал эмнэлэгтэй гэрээ байгуулан 280,000-300,000 төгрөгийн багц үзлэг шийнжилгээнд 89 албан хаагчийг хамруулахаар Газрын даргын 2025 оны Б/169 дүгээр тушаалаар батлуулсан боловч Төрийн хэмжэлтийн хуулийн хүрээнд санхүүжилт хүлээгдэж байгаа болно. (89 албан хаагч, 26,040,000 төгрөг)
		Албан хаагчдын хамрагдалт	Албан хаагчийн тоо	96	100	66	Z:\0.KHOT BAIGUULALT, KHOTIIN STANDARTIIN GAZAR\8. HUNII NUUTSIIN MEDEEEL\6. 2025\9. ERUUL MENDIIN UDURLUG & UZLEG
		Эрүүл мэндийн шалтгаанаар гадаад, дотоодод эмчлүүлэх болон бусад төрлийн дэмжлэг тусалцааг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу үзүүлэх	Тоо	8	6-10 хүртэл	18 албан хаагч	Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эрүүл мэндийн шалтгаанаар хүсэлт гаргасан 18 албан хаагчийн хүсэлтийг журмын дагуу шийдвэрлэсэн байна. Үүнд - эрүүл мэндийн зайлшгүй шалтгаанаар хагалгаанд орсон 5 албан хаагчид Газрын даргын 2025 оны Б/31, Б/63, Б/96, Б/144, Б/146, дугаар тушаалаар тус бүр 1,000,000 сая төгрөгийн тэтгэмж, сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан 1 албан хаагчид Газрын даргын Б/143 тушаалаар 500,000 төгрөгийн тэтгэмж,

1	2	3	4	5	6	7	8
							Б/152 дугаар тушаалаар гэр бүлийн гишүүнийг асрахаар чөлөө хүссэн 1 албан хаагчид 500,000 төгрөгийн тэтгэмж тус тус олгов. - эрүүл мэндийн шалтгаанаар урт хугацааны давтан үзлэг, эмчилгээ хийлгэх шаардлагатай 1 албан хаагчид Газрын даргын 2025 оны Б/66 дугаар тушаалаар 1 сарын буюу 21 хоногийн цалинтай чөлөө, - эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар гам барих шаардлагатай болсон 1 албан хаагчид Газрын даргын 2025 оны Б/68 дугаар тушаалаар 56 хоногийн цалингүй чөлөө, - эрүүл мэндийн шалтгаанаар гадагшаа үзлэг шинжилгээнд хамрагдах шаардлагатай 2 албан хаагчид Газрын даргын 2025 оны Б/95, Б/165 дугаар тушаалаар ажлын 7-40 хоногийн цалингүй чөлөө, - удаан хугацаагаар эмчилгээнд хамрагдах, аав ээжийгээ болон гэр бүлийн гишүүнийг асрамжлахаар гаргасан хүсэлтийн дагуу 5 албан хаагчид Газрын даргын 2025 оны Б/123, Б/139, Б/147, Б/163, Б/182 дугаар тушаалаар ажлын 10-63 цалингүй чөлөө, - Ар гэрийн зайлшгүй шалтгаанаар гадаад улсад зорчихоор хувийн чөлөө хүсэж хүсэлт гаргасан 2 албан хаагчид Газрын даргын 2025 оны Б/131, Б/170 тушаалаар ажлын 30-39 хоногийн цалингүй чөлөө.
2. АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ							
2.1	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд	Албан хаагчийн тоо	Давхардсан тоогоор 23 албан хаагч	20 хүртэл албан хаагч	18 албан хаагч	Газрын даргын тушаалаар гадаадын богино хугацааны сургалтын хөтөлбөрт хамрагдсан 18 албан хаагчдад суралцах хугацааны үндсэн цалинг олгож шийдвэрлэсэн байна. Үүнд 1.Тайвань улсын Тайпэй болон Гаосюн хот

1	2	3	4	5	6	7	8
		эрхэлж байгаа албан тушаалын цалинг олгох;					“Ухаалаг хотын дээд хэмжээний экспо-2025” чуулганд 2 албан хаагч, ажлын 10 хоногийн, 2.Солонгос Улс, Бусан хотын захиргаа, Бусан хотын Онцгой байдлын газар “Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа ба эрт зарлан мэдээлэх систем” сэдэвт сургалтын хөтөлбөрт 1 албан хаагч, ажлын 5 хоногийн, 3.Солонгос Улсын Сөүл хотын захиргаа, Сөүлийн үндэсний их сургууль “Монголын хот байгуулалтын мэргэжилтнүүдэд зориулсан Сөүл дэх чадавхыг бэхжүүлэх” сургалтын хөтөлбөрт 2 албан хаагч, ажлын 14 хоногийн, 4.Япон Улсын Токио хотноо зохион байгуулагдах “Шинэ хот байгуулахтай холбоотой эрх зүйн орчин, төлөвлөлт, эдийн засгийн тусгай бүсийн хөгжилтэй холбоотой эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт, институтийн ойлголт” сэдэвт сургалтын хөтөлбөрт 1 албан хаагч, ажлын 6 хоногийн, 5.Хятад улсын Гуанжу хот, Дэлхийн банк болон Хятадын хөгжлийн төвөөс хамтран зохион байгуулагдах “Тогтвортой хотуудын дэлхийн платформ (GPSC)” хөтөлбөрт 1 албан хаагч, ажлын 5 хоногийн, 6.Америкийн Нэгдсэн Улс, Төр, нийтийн үйлчилгээ, ёс зүйн сургуулиас зохион байгуулсан “Төр, нийтийн удирдлага”-ын сургалтын хөтөлбөрт 2 албан хаагч, ажлын 20 хоногийн, 7.Энэтхэг улсын “Хайдерабад”-ын их сургуулийн “Course in Progress to proficiency in english literacy-I” сургалтын хөтөлбөрт 2 албан хаагч, ажлын 19 хоногийн, 8.“КОЙКА”-ийн дэмжлэгээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх” төслийн хүрээнд БНСУ-д зохион

1	2	3	4	5	6	7	8
							байгуулагдах албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтын хөтөлбөрт 2 албан хаагч, ажлын 8 хоногийн, 9.Монголын Мянганы сорилтын сангаас Монгол Улсын усны компакт гэрээний хүрээнд Нидерландын Vitens Evides International (VEI) байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй Нидерланд улсын “Усны операторуудын түншлэлийн хөтөлбөр” сургалтын хөтөлбөрт 1 албан хаагч, ажлын 8 хоногийн, 10. Солонгос Улсын Кёнсанбүг мужийн захиргаа, Эрчим хүчний үндэсний төв “Байгальд ээлтэй эрчим хүч, ногоон хотуудыг бий болгох” чиглэлээр байгуулсан гэрээний хүрээнд төрийн албан хаагчдад хоёр орны хамтын ажиллагааны төслүүдийг танилцуулах уулзалт, сургалтын хөтөлбөрт 1 албан хаагч, ажлын 5 хоногийн, 11. Солонгос Улсад зохион байгуулагдах “Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ухаалаг, дижитал хотын авто тээврийн мастер төлөвлөгөө” боловсруулах төслийн чадавх бэхжүүлэх хөтөлбөрт 1 албан хаагч, ажлын 5 хоногийн, 12. Тайваний Олон Улсын газрын бодлого судалгаа, сургалтын төв, “Газарзүйн мэдээллийн систем ба газрын менежмент” сэдэвт сургалтын хөтөлбөрт 1 албан хаагч, ажлын 10 хоногийн, 13. Монголын Мянганы сорилтын сангаас хэрэгжүүлж буй “Хаягдал ус дахин боловсруулах төсөл”-ийн хүрээнд Олон улсын туршлага судлах аялалд 2025 оны 1 албан хаагч, ажлын 8 хоногийн.
		Хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт,	Албан хаагчийн тоо	Давхардсан тоогоор 295	128 албан хаагч (хагас	192 албан хаагч Давхардса	1.Газрын даргын 2025 оны Б/91 дүгээр тушаалаар 2024 оны Аудитын дүгнэлтээр “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан Захиргаа, удирдлагын

1	2	3	4	5	6	7	8
		ажлын үр дүнтэй уялдуулан урамшуулал олгож, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх зарчмыг хангах		албан хаагч	бүтэн жилээр)	н тоогоор	хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч нарыг тус бүр 2 сарын үндсэн цалингаар, (нийт 10,184,000 төгрөг), 2.Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2025 оны эхний хагас ажлын үр дүнгээр “Маш сайн”, “Сайн” үнэлэгдсэн 98 албан хаагчид Газрын даргын 2024 оны Б/92 дугаар тушаалаар үр дүнгийн 117,466,000 төгрөгийн урамшуулал олгов. 3.Нийслэлийн Засаг даргын 2025 оны “2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх тухай” А/905 дугаар захирамжаар Хот байгуулалт, хотын стандартын газрын эхний хагас жилийн ажлын дүнгээр “Хангалттай” үнэлэгдсэн Газрын дарга Г.Баярсайханыг 1 сарын үндсэн цалингаар урамшуулав. 4.Газрын даргын 2025 оны Б/167 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хороо”-ны 7 гишүүнд 2025 оны 4 дүгээр улиралд олгох урамшуулал болох 5,940,000 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн боловч төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд санхүүжилт хийгдээгүй, хүлээгдэж байна. 5.Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2025 оны сүүлийн хагас жилийн ажлын үр дүнгээр “Маш сайн”, “Сайн” үнэлэгдсэн 83 албан хаагчид үр дүнгийн 108,218,500 төгрөгийн урамшуулал олгохоор тушаалын төсөл боловсруулан баталгаажуулах ажил хүлээгдэж байна.
2.2	Албан хаагчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг	Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан”, Сангийн яамны “Төрийн албаны цалингийн нэгдсэн	Гүйцэтгэл, хувь	100	100	100	Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим системд шинэчлэн баталсан төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, шинэчлэн тогтоосон албан тушаалын цалин, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид

1	2	3	4	5	6	7	8
	сайжруулж, тэдний нийгмийн баталгааг үе шаттайгаар дээшлүүлнэ.	систем", нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн программд төрийн албан хаагчдын хувийн хэрэг, сургалт, цалин хөлс, сахилгын болон ёс зүйн зөрчил, томилгоо, чөлөөлөлттэй холбоотой бүх мэдээллийг тухай бүр оруулах, баяжилт хийх, тайлан мэдээг гаргах					төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, албан хаагчдын ажилласан жилийн түүхийг албан хаагчийн хамтаар мэдээллийг бүрэн гүйцэт, үнэн зөв оруулж тайлагнав. (идэвхтэй 105 албан хаагч, ажиллахгүй байгаа 213 нийт 318 албан хаагчийн мэдээлэл) Төрийн албаны зөвлөлийн 2022 оны оны 600 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу төрийн албан хаагчийн анкетыг шинэчилсэн загвараар гаргуулан хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлэв. (36 албан хаагч) Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 238 дугаар тогтоолын дагуу Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын цахим системд Газрын даргын 2025 оны "Албан хаагчдын албан тушаалын цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай" Б/03 дугаар тушаал (105 албан хаагчийн)-ын цалин, бусад нэмэгдлийн мэдээллийг оруулж, өөрчлөлт хийв.
2.3		Албан хаагчдын боловсрол мэргэжил, зэрэг дэв, мэргэшлийн зэрэг, улсад болон төрийн албанд, тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, ахуй амьжиргааны нөхцөл байдлыг тогтоох нийгмийн хамгааллын чиглэлийн бүртгэл судалгааг нарийвчлан гаргах	Гүйцэтгэл, хувь	100	100	100	1. Хүний нөөцийн үзүүлэлт судалгаа (хүйс, улсад, төрийн албанд, тухайн байгууллагад ажилласан жил, зэрэг дэв, насны ангилал, насны ангилал хүйсээр) 2. Хүний нөөцийн үзүүлэлт судалгаа (мэргэжил, мэргэшсэн байдал) 3. Орон сууцны хөтөлбөрт хамрагдсан байдлын судалгаа (2016-2024) W:\2025\5. Hunii nuutsiin hutulbur\1. TAZ & SALBAR ZUVLUL_TAJX-iin NUUTSIIN MEDEE & BUSAD TAILAN MEDEE W:\2025\9. Sudlagaa & medeelel Албан хаагчдын улсад ажилласан болон төрийн албанд ажилласан жилийн судалгааг 2025 оны 1 дүгээр сард нэмэгдсэн жилээр шинэчлэн тогтоож,

1	2	3	4	5	6	7	8
							цалин нэмэгдэл болон ээлжийн амралтын хуваарийг нийт албан хаагчдаар баталгаажуулав.
2.4		Албан хаагчдын орон сууцны нөхцөлийн судалгааг нарийвчлан гаргаж, Засгийн газар, нийслэлийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн болон түрээсийн хөтөлбөрт албан хаагчдын эрэлт хэрэгцээнд үндэслэн хамруулах, захиалга, хүсэлтийг уламжлан шийдвэрлүүлэх замаар орон байрны нөхцөлийг дээшлүүлэх	Гүйцэтгэл, хувь	100	100	100	Нийслэлийн Засаг даргаас санаачлан хэрэгжүүлсэн албан тушаалын орон сууцанд албан хаагчдыг хамруулах хөтөлбөрт 2025 оны эхний ээлжид 5 албан хаагч хамрагдахаас 1 албан хаагч өөрийн хүсэлтээр татгалзаж, 4 албан хаагч хамрагдаж, албан тушаалын орон сууцанд орсон. Хот байгуулалт, хотын стандартын газрын нийт ажиллаж байгаа 104 албан хаагчаас Нисэх, Яармагт 39 албан хаагч буюу нийт албан хаагчдын 37 хувь амьдардаг, үүнээс түрээсийн байранд 8 албан хаагч түр оршин сууж байна. 2024 онд түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцны болон албан тушаалын орон сууцны судалгаанд 42 албан хаагч хамрагдах хүсэлт гаргасныг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 3-4 удаа өгсөн бөгөөд дараагийн ээлжид байгууллагаас гэр хороололд амьдардаг болон Төв аймаг, Баянзүрх дүүргийн алслагдсан хороонд амьдардаг албан хаагчдаас нэр дэвшүүлэх хүсэлтийг Газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/661 албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтэст хүргүүлсэн.
2.5		Албан хаагчдыг зуслангийн газартай болгох, зохих дэмжлэг үзүүлэх	Гүйцэтгэл, хувь	100	100	10 албан хаагч 100%	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/301 дүгээр захирамжаар олгосон Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Ар хөндлөнгийн аманд байрлах зуслангийн зориулалттай 5.0 га газрыг албан хаагчдад зуслангийн зориулалтаар эзэмшүүлэхээр Газрын даргын 2020 оны Б/90 дүгээр тушаалаар батлуулав. (хамрагдсан албан хаагчийн тоо 120). Дээрх Ар хөндлөнгийн аманд байрлах зуслангийн газарт 2024-2025 онд шинээр томилогдсон 10

1	2	3	4	5	6	7	8
							албан хаагчдад нэмэлтээр газар олгож, гэрчилгээг олгосон.
2.6		Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг зохих журмын дагуу шинээр болон ахиулан олгох	Гүйцэтгэл, хувь	100	100	100	Улсын Их хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу нийт 26 албан хаагчийн зэрэг дэвийг шинэчлэн тогтоолгох санал хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/578 дугаар захирамжаар батлагдаж шинээр тогтоосон зэрэг дэвийн нэмэгдлийг 05 дугаар сарын 01-ний өдрөөс олгов. (19 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, шинээр 7 албан хаагчид)
2.7		Төрийн албанд ажилласан жилийг үнэн зөв тодорхойлж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг зохих журмын дагуу олгох	Гүйцэтгэл, хувь	100	100	100	Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо, цахим системд шинэчлэн баталсан төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, шинэчлэн тогтоосон албан тушаалын цалин, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, албан хаагчдын ажилласан жилийн түүхийг албан хаагчийн хамтаар мэдээллийг бүрэн гүйцэт, үнэн зөв оруулж тайлагнав. (идэвхтэй 118 албан хаагч, ажиллахгүй байгаа 191 нийт 309 албан хаагчийн мэдээлэл)
2.8		Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлж, ур чадварын нэмэгдэл олгох	Албан хаагчийн тоо	19	33	59 албан хаагч давхардсан тоогоор	Газрын даргын 2025 оны Б/91 дүгээр тушаалаар 2024 оны Аудитын дүгнэлтээр “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч нарт тус бүр 2 сарын үндсэн цалингийн урамшуулал олгов. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2025 оны эхний хагас ажлын үр дүнгээр “Маш сайн”, “Сайн”

1	2	3	4	5	6	7	8
							үнэлэгдсэн 30 албан хаагчид Газрын даргын 2025 оны Б/92 дугаар тушаалаар үр дүнгийн урамшуулал олгов. 2025 оны сүүлийн хагас жилийн ажлын үр дүнгээр “Маш сайн”, “Сайн” үнэлэгдсэн төрийн үйлчилгээний 27 албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгох шийдвэрийн төсөл боловсруулан, баталгаажилт хүлээгдэж байна. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын дагуу төрийн үйлчилгээний 22 албан хаагчид ур чадварын нэмэгдэл 10-25 хувийг Газрын даргын тушаалаар сар бүр олгож байна.
2.9		Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, эерэг харилцаа хандлага, мэргэшсэн, тогтвортой үйл ажиллагааны шалгуурыг харгалзан Тэргүүний албан хаагчдыг төрийн дээд цол, одон, медаль, салбарын болон нийслэлийн шагналаар шагнуулахаар тодорхойлох, холбогдох журмын дагуу мөнгөн шагнал олгох.	Гүйцэтгэл, шагнагдсан албан хаагчийн тоо	57 албан хаагч	50 албан хаагч	12 албан хаагч	Ардын хувьсгалын 104 жилийн ой, Улсын их баяр наадам, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын баярын өдрийг тохиолдуулан хамт олноо манлайлан амжилт гарган ажилласан 62 албан хаагчийг шагналд нэр дэвшүүлж тодорхойлолт хүргүүлснээс 41 албан хаагч шагнагдсан байна. Үүнд: 1. Тэргүүний барилгачин цол тэмдгээр 1 албан хаагч 2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны “Жуух бичиг”-ээр 1 албан хаагч, 3. Хууль зүй, дотоод хэргийн яамны “Хүндэт Жуух бичиг”-ээр 2 албан хаагч 4. Төрийн албаны Тэргүүний ажилтан цол тэмдгээр 2 албан хаагч, 5. НИТХ-ын “Хүндэт тэмдэг”-ээр 5 албан хаагч, 6. НИТХ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр 2 албан хаагч, 7. НИТХ-ын “Хүндэт үнэмлэх”-ээр 3 албан хаагч, 8. “Нийслэлийн Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 2 албан хаагч, 9. Нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 4

1	2	3	4	5	6	7	8
							албан хаагч, 10.Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн "Өргөмжлөл"-өөр 7 албан хаагч, 11.Монголын Залуучуудын холбоо "Шилдэг залуу" цол тэмдгээр 12 албан хаагч. 2023-2024 онд Төрийн одон медальд тодорхойлогдсон 2 албан хаагч Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одонгоор шагнагдсан байна.
2.10		Албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардал, өдрийн хоолны мөнгийг баталсан төсвийн хүрээнд сар бүр олгох	Хувь	100	100	100	Албан хаагчдын ажилдаа ирж буцах нийтийн тээврийн унааны зардал 1000 төгрөг, өдрийн хоолны зардал 34000 төгрөгийг баталсан төсвийн хүрээнд сар бүр олгож байна.
2.11		Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах	Хувь	2	2	2	Байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан 16 ахмад ажилтанд сар шинийн баяраар тус бүр 200,000 төгрөгийн тэтгэмжийг Ахмадын сангаас 2 сард олгосон байна. 2025 оны Олон улсын ахмадын баярыг тохиолдуулан 10 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын 17 ахмад ажилтныг байгууллага дээр хүлээж, хүндэтгэл үзүүлсэн. Ахмадын сангаас тус бүр 200,000 төгрөгийн тэтгэмж олгосон. Байгууллагын өндөр настан 2 ахмад ажилтан 2025 онд өвчний улмаас болон зуурдаар нас барахад нийт хамт олноос 4,788,000 төгрөгийн сэтгэлийн дэмжлэг, Ахмадын сангаас тус бүр 1,000,000 төгрөгийн тэтгэмж олгосон.
2.12		Ажлын зайлшгүй шаардлагаар илүү цагаар, шөнийн цагаар, долоо	Хувь	100	100	100	Ажлын зайлшгүй шаардлагаар оройн цагаар болон амралтын өдрүүдэд илүү цагаар ажилласан илүү цагийн нэмэгдэл хөлсийг 11 удаа

1	2	3	4	5	6	7	8
		хоногийн амралтын өдрөөр ажилласан, эсхүл албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсэн албан хаагчдад холбогдох журмын дагуу илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгох					(1-11 сар) давхардсан тоогоор 376 албан хаагчдад зохих журмын дагуу олгосон байна. (68,963,198 төгрөгийн нэмэгдэл хөлс) Илүү цагаар ажилласан ажлын тайлан мэдээг тухай бүр санхүүд тайлагнаж ажиллав.
2.13		Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Мөнгөн дүн	34,017,000 төгрөг	Гүйцэтгэлээр	130,195,167 төгрөг	Төрийн албаны тухай хууль болон Газрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 21 албан хаагчид 130,195,167 төгрөгийн тэтгэмж, цалинтай чөлөөг 12 албан хаагчид (97 ажлын хоног), цалингүй чөлөөг 21 албан хаагчид (454 ажлын хоног) тус тус Газрын даргын тушаалаар (4-өөс дээш хоногийн захиргааны чөлөө) олгов. M:\2025\5. Hunii nuutsiin hutulbur\1. TAZ & SALBAR ZUVLUL_TAJX-iin NUUTSIIN MEDEE & BUSAD TAILAN MEDEE Тэтгэмж олгосон байдал: 1. Шинэ хүүхэдтэй болсон 9 албан хаагч 1,350,000 төгрөг, 2. Эрүүл мэндийн зайлшгүй шалтгаанаар хагалгаанд орсон 5 албан хаагч 5,000,000 төгрөг, 3. Албан хаагчийн гэр бүлд ажил явдал гарсан 2 албан хаагчид 400,000 төгрөг, 4. 1 сараас дээш хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан 1 албан хаагч 500,000 төгрөг, 5. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гэр бүлийн гишүүнийг асран халамжлахаар хүсэлт гаргасан 1 албан хаагч 500,000 төгрөг, 6. Тэтгэвэр тогтоолгох насанд хүрч 36 сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн

1	2	3	4	5	6	7	8
							буцалтгүй тэтгэмж 3 албан хаагч 122,445,167 төгрөг.
2.14	Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын хүрээнд Газрын хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	Хөдөлмөрийн дотоод журамд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын зохицуулалтын хүрээнд тэтгэмж, тусламж олгохтой холбоотой харилцааг шинэчлэн тусгаж, хамт олны саналыг тусган тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталж, мөрдөх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100% (Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан)	100%		Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/443 дугаар захирамжаар Хот байгуулалт, хотын стандартын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан Газрын Хөдөлмөрийн дотоод журмыг нийт албан хаагчдаас санал авч танилцуулан шинэчлэн боловсруулж, 2024 оны А68 дугаар тушаалаар тушаалаар баталсан. Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын зохицуулалтын хүрээнд Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Хуулийн хэлтэс нийт нэгж, албан хаагчдаас санал авч, удирдлагад танилцуулан, батлуулах ажил хүлээгдэж байна.

ТАНИЛЦСАН: ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Д.ДАШЦЭЦЭГ

Т.БУЯНЖАРГАЛ

У.УЯНГА